



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/104/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дүгээр сарын 05</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Төлбөрийн акт	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

ЗДБ.ОД.17 № 2/69

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд

003020306

67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 81.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including 'Аудитын байгууллага' (Audit Agency) and 'Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу' (According to the International Standards on Auditing of the Public Sector). The signature is a stylized, cursive script.

Б.МӨНХБАТ

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,222,312.00</u>	<u>19,975,768.00</u>
33	АВЛАГА	389,112.00	7,142,568.00
335	Бусад авлага	389,112.00	7,142,568.00
3351	Байгууллагаас авах авлага	389,112.00	7,142,568.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,833,200.00	12,833,200.00
354	Хангамжийн материал	12,833,200.00	12,833,200.00
35410	Бичиг хэргийн материал	1,754,110.00	1,754,110.00
35420	Аж ахуйн материал	11,079,090.00	11,079,090.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>97,943,132.13</u>	<u>142,998,896.24</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	97,943,132.13	142,998,896.24
392	Биет хөрөнгө	97,943,132.13	142,998,896.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,268,000.00	2,268,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,475,931.99	-1,513,731.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	157,549,000.00	95,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	125,867,333.47	-26,029,166.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,075,680.00	101,475,680.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,235,759.01	-45,307,948.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,509,550.00	43,509,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,193,373.40	-27,706,786.75
39217	Ном	313,300.00	313,300.00
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>111,165,444.13</u>	<u>162,974,664.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>1,024,401.39</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,024,401.39
413	Өглөг	00.00	1,024,401.39
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,024,401.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>111,165,444.13</u>	<u>161,950,262.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	111,165,444.13	161,950,262.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	206,028,121.00	206,028,121.00
51101	Өмч: - төрийн	206,028,121.00	206,028,121.00
512	Хуримтлагдсан үр дүн	-96,166,342.87	-45,381,524.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-96,166,342.87	-96,166,342.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	50,784,818.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,303,666.00	1,303,666.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>111,165,444.13</u>	<u>162,974,664.24</u>

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	948,994,800.00	1,718,181,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,623,000.00	29,700,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,623,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,623,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,917,000.00	00.00
122	Тусламжийн орлого	00.00	29,700,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	29,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	937,371,800.00	1,688,481,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,060,000.00	228,556,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,060,000.00	228,556,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	799,311,800.00	1,459,925,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	799,311,800.00	1,459,925,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	922,395,601.06	1,667,396,681.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	922,395,601.06	1,667,396,681.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	780,102,510.82	1,520,889,264.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,948,423.34	707,195,098.00
210101	Үндсэн цалин	216,948,423.34	707,195,098.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,271,165.43	81,935,255.16
210201	Тэтгэврийн даатгал	19,829,656.99	56,182,898.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,175,088.91	6,153,104.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	919,906.58	4,922,484.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,231,652.77	1,146,179.12
210205	Эрүүл мэндийн даатгал	4,114,860.18	13,530,588.93
2104	Хангамж, бараа материалын зардал	41,558,709.00	37,170,999.62
210401	Бичиг хэрэг	7,461,991.00	5,089,700.00
210402	Тээвэр, шатахуун	30,247,616.00	28,781,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,976,102.00	2,999,999.62
210404	Ном, хэвлэл	00.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	873,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,350,000.00	694,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000.00	694,200.00
210604	Урсгал засвар	8,320,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	7,927,400.00	7,980,000.00
210702	Дотоод албан томилолт	7,927,400.00	3,280,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	4,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,440,000.00	349,336,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,030,000.00	336,606,730.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	00.00

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	1,060,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	810,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	69,346.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	11,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,606,813.05	336,577,635.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	187,205,300.00	306,543,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,401,513.05	30,034,235.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,293,090.24	146,507,416.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,378,600.00	135,150,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123,970,000.00	133,150,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,408,600.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	914,490.24	11,350,316.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	914,490.24	11,350,316.61
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	26,599,198.95	50,784,818.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,866,579.78	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,866,579.78	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,866,579.78	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	20,732,619.17	50,784,818.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	937,371,800.00	1,688,481,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	937,371,800.00	1,688,481,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,060,000.00	228,556,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,060,000.00	228,556,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	799,311,800.00	1,459,925,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	799,311,800.00	1,459,925,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	897,648,200.00	1,643,091,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,648,200.00	1,643,091,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	755,355,109.76	1,496,584,083.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,841,506.99	710,563,640.50
210101	Үндсэн цалин	149,744,800.00	124,794,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,483,000.00	8,712,000.00
210104	Урамшуулал	58,613,706.99	577,057,340.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,767,193.77	82,270,767.27
210201	Тэтгэврийн даатгал	19,400,649.00	59,527,601.21

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	2,175,089.26	6,132,658.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,731,791.47	3,362,988.16
210204	Ажилгүйдлийн даатгал	404,671.24	519,565.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,054,992.80	12,727,953.32
2104	Хангамж, бараа материалын зардал	35,273,709.00	28,380,399.62
210401	Бичиг хэрэг	7,297,607.00	5,080,800.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	19,999,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,976,102.00	2,999,999.62
210404	Ном, хэвлэл	00.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,900,000.00	13,694,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	13,694,200.00
210604	Урсгал засвар	8,900,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	7,927,400.00	7,980,000.00
210702	Дотоод албан томилолт	7,927,400.00	3,280,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	4,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,440,000.00	346,746,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,030,000.00	326,016,730.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,060,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	810,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	69,346.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	19,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	187,205,300.00	306,949,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	187,205,300.00	306,949,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,293,090.24	146,507,416.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,378,600.00	135,150,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123,970,000.00	133,150,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,408,600.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	914,490.24	11,350,316.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	914,490.24	11,350,316.61
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>39,723,600.00</u>	<u>45,390,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>39,723,600.00</u>	<u>45,390,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>39,723,600.00</u>	<u>45,390,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>39,723,600.00</u>	<u>45,390,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,723,600.00	45,390,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-39,723,600.00</u>	<u>-45,390,000.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-176,488,279.74	31,943,507.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-176,488,279.74	31,943,507.26
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,353,397.65	10,353,397.64
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-96,166,342.87	111,165,444.13
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-96,166,342.87	111,165,444.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-96,166,342.87	111,165,444.13
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	50,784,818.72	50,784,818.72
D09	2012 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-45,381,524.15	161,950,262.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,459,925,000.00	1,448,574,683.39	11,350,316.61	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,459,925,000.00	1,448,574,683.39	11,350,316.61	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,444,749,600.00	1,433,423,783.39	11,325,816.61	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	714,619,100.00	710,563,640.50	4,055,459.50	99.4
210101	Үндсэн цалин	124,794,300.00	124,794,300.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,712,000.00	8,712,000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	581,112,800.00	577,057,340.50	4,055,459.50	99.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,327,400.00	82,270,767.27	7,056,632.73	92.1
210201	Тэтгэврийн даатгал	60,742,700.00	59,527,601.21	1,215,098.79	98.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,146,200.00	6,132,658.98	1,013,541.02	85.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,716,900.00	3,362,988.16	2,353,911.84	58.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,429,200.00	519,565.60	909,634.40	36.4
210205	Эрүүл мэндийн даатгал	14,292,400.00	12,727,953.32	1,564,446.68	89.1
2104	Хангамж, бараа материалын зардал	28,384,600.00	28,380,399.62	4,200.38	100.0
210401	Бичиг хэрэг	5,084,600.00	5,080,800.00	3,800.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	20,000,000.00	19,999,600.00	400.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,999,999.62	0.38	100.0
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,750,000.00	13,694,200.00	55,800.00	99.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,750,000.00	13,694,200.00	55,800.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	7,980,000.00	7,980,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	3,280,000.00	3,280,000.00	0.00	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,700,000.00	4,700,000.00	0.00	100.0

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	250,688,500.00	250,595,776.00	92,724.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	217,478,500.00	217,466,430.00	12,070.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	810,000.00	810,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	69,346.00	80,654.00	46.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,000,000.00	32,000,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	340,000,000.00	339,939,000.00	61,000.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	340,000,000.00	339,939,000.00	61,000.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,175,400.00	15,150,900.00	24,500.00	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,175,400.00	15,150,900.00	24,500.00	99.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,175,400.00	13,150,900.00	24,500.00	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,459,925,000.00	1,448,574,683.39	11,350,316.61	99.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,459,925,000.00	1,448,574,683.39	11,350,316.61	99.2
320001	Орон нутгийн төсвөөс	1,459,925,000.00	1,448,574,683.39	11,350,316.61	99.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	27	27	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13	13	0.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,060,000.00	228,550,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,060,000.00	228,550,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,060,000.00	108,550,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,060,000.00	108,550,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,060,000.00	108,550,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,000,000.00	120,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,000,000.00	120,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	120,000,000.00	120,000,000.00

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

П	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,060,000.00	228556500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,060,000.00	228,556,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,060,000.00	228,556,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь “ Нутгийн өөрийн удирдлагын алсын хараатай бодлого, ил тод, хариуцлагатай төрийн үйлчилгээ, иргэдийн бүтээлч санаачилга, өргөн боломжид суурилсан, тогтвортой хөгжлийг бий болгож, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэн аж жаргалтай, амар тайван амгалан амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилго доор үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд байгууллагын Дотоод хяналт шалгалтын зөвлөл, ажиллах журмыг байгууллагын даргын 2020 оны А\49 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Дотоод хяналт, шалгалтын зөвлөл хагас, бүтэн жилээр байгууллагын болон албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж журмын хэрэгжилтийг хангаж ажилладаг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аймгийн СТСХ-ээс гаргасан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 162,974.6 мянган төгрөг болж өмнөх оноос 51,809.2 мянган төгрөгөөр буюу 31.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	389.10	7,142.50	6,753.40
Бараа материал	12,833.20	12,833.20	0.00
Үндсэн хөрөнгө	97,973.10	142,998.90	45,025.80
Хуримтлагдсан элэгдэл	-182,222.30	-101,007.60	81,214.70
Нийт хөрөнгө	111,165.40	162,974.60	51,809.20
Өр төлбөр	0	1024.4	1,024.40
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	111,165.40	161,950.20	50,784.80
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	111,165.40	162,974.60	51,809.20

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 7,142.5 мянган төгрөг болж өмнөх оноос 6,753.4 мянган төгрөгөөр өссөн нь М.Мөнхбатад 2025.0 төгрөгийн гүйлгээг сангийн системийн гацалтаас шалтгаалан давхардуулан гүйлгээ хийгдсэн ГХУСА33-ын Дээлтэй Баянхонгор арга хэмжээний зардлын авлага, ХХОАТ-ын суутгалаас үүссэн авлага 5117.5 мянгыг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд тайланд онд өөрчлөлт ороогүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 142,998.9 мянган төгрөг болж өмнөх оноос 45,025.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ИТХ-ын тогтоолоор Галуут сумын ЭМТ-ын данс бүртгэлд байсан 29,700.0 мянган төгрөгийн өртөг бүхий УАЗ фургон автомашиныг шилжүүлэн, байгууллагын батлагдсан төсвийн хөрөнгөөр 19,990.0 мянган төгрөгийн суудлын Toyota Vanguard маркийн автомашин, 25,400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсантай холбоотой байна.

Тайлант оны эхэнд өр төлбөргүй байсан бөгөөд НДХ-т цалингийн олон нийтийн цагдаа нарын кодыг андууран мэдээлсэнтэй холбоотойгоор 1,024.4 мянган төгрөгийн НДШ-ын өглөг үүссэн байна

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 161,950.2 мянган төгрөг болж 50,784.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 50,784.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 882,982.5 мянга, нийт зарлагыг 882,982.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 805,499.0 мянган төгрөгөөр өсөж 1,688,481.5 мянган төгрөг болгож 805,499.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь тус байгууллагаас олон нийттэй харьцах цагдаагийн урамшуулалт цалинг дамжуулан олгодог болсонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70105 хөтөлбөрийн 80101, 80205, 80802, 80815, 80830, 82201, 82310 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,459,925.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,459,925.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,459,925.0 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 228,556.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, оны эцэст 11,350.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,448,574.6 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 11,350.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,113,749.6	1,102,427.2	11,322.4	99.0
2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,000.0	1,000.0	0.0	100.0
3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,000.0	2,000.0	0.0	100.0
4	80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн тэтгэмж	10,205.4	10,205.4	0.0	100.0
5	80830	Цагаатгалын нөхөн олговор	2,970.0	2,945.5	24.5	99.2
6	82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	180,000.0	180,000.0	0.0	100.0
7	82310	Гамшгаас сэргийлэх сургалт, сургалт сурталчилгааны зардал	150,000.0	150,000.0	0.0	100.0
Нийт			164,559,175.0	164,434,324.9	124,850.1	99.9

Эх сурвалж Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030050401 тоот дансанд цагаатгалын нөхөн төлбөрт 120,000.0, аймгийн ЗДТГ-аас 99,000.0, ГХУСГ-хамтарсан багийн зардал 9,000.0, Нутгийн өөрөө удирдах байгууллагын ИЧБТ-ээс Говь-Алтай аймагт болох сургалтын зардал 556.5 нийт 228,556.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж оны эцэст улсын төсөвт 6.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого /мян.төгрөгөөр/

№	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	ЦАУЗБУК-оос цагаатгал нөхөн төлбөр	120,000.0
2	Бх.Засаг дарга-Төслийн хэрэгжилтийн санхүүжилт	99,000.0
3	НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ИЧБТ	556.5
4	ГХУСАЗЗААлба- хамтарсан багийн зардал	9,000.0
Нийт		228,556.5

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Хүснэгт 4. Нэмэлт санхүүжилтийн зарлага /мян.төгрөгөөр/

№	Гүйлгээний үтгэ	Зарлага
1	Бичиг хэргийн зардал	530.00
2	Далбааны үнэ	1,848.00
3	Хөтөлбөрийн хэрэгжилт	47,199.80
4	Мини парламентын мөнгө	472.50
5	Мэтгэлцээний зардал	6,300.00
6	Нөхөх олговор	120,000.00
7	Нэг хүүхэд нэг нүүдэл төслийн мөнгө	15,000.00
8	Соёрхол тэмдэг үнэмлэхийн үнэ	2,000.00
9	Бараа үйлчилгээний бусад зардал	35,206.20
Нийт		228,556.50

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 21-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Т.Норов, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Ариунбаяр нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,662,147.5 мянган төгрөгөөс 17,452.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 17,452.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлбэл зохих/ удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлэл байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	0	6	4	1
2	Хагас жил	4	4	0	4	0	0
3	Улирал бүр	1	4	0	0	4	
4	Сар бүр	3	36	24	12		
5	Тухай бүр	8	96	82	11	3	
	Нийт	27	151	106	33	11	1

Тус байгууллага нь 2022 онд нийт Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс 218820.0 мянган төгрөгийн 33 мэдээлэл хугацаа хоцроож тухай бүр мэдээлэх 3, улирал бүр мэдээлэх 3, бүтэн жилээр мэдээлэх 5 нийт 11 мэдээллийг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 34,096.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс санхүүгийн аудитын 24,869.1 мянга, нийцлийн аудитын 105,339.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна. Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022.05.30-ны өдрийн 16/848 дүгээр албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	4	38,589.8	4	38,589.8	100
Нийт дүн	4	38,589.8	4	38,589.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 180,000.0 мянга, Гамшгаас сэргийлэх сургалт, сургалт сурталчилгааны зардал 150,000.0

мянга нийт 330,000.0 мянган төгрөг батлагдаж зарцуулагдсан ба төлөвлөлт, гүйцэтгэлийг энэ аудитад хамруулан шалгаагүй завсрын аудитаар үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 263,624.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,024.0 мянган төгрөгийн алдааг зөрчилд 1 албан шаардлага, нийцлийн аудит буюу шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 218,820.0 мянга, татварын э-баримт шивэлттэй холбоотой 43,780.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг тус тус дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,024.4 мянган төгрөгийн НДШ-ын өглөгтэй тайланг гаргасан ба аудитын явцад цалинг ТАЦНС болон НДШ-7,8 мэдээтэй тулган шалгахад 3,912.6 мянган төгрөгийн НДШ-ын авлага үүсэж байгаа боловч олон нийтдээ харилцах цагдаа нарын шимтгэл төлөлтийн кодыг төрийн тусгайгаар мэдээлсэнтэй холбоотой бөгөөд кодын зөрүүг гаргахад 1,024.4 мянган төгрөгийн өглөг үүсэж санхүүгийн тайланд тусгасан байна. Кодын зөрүүтэй мэдээлсэн олон нийтийн цагдаа нарын НДШ-7,8 мэдээг залруулж мэдээлэх албан шаардлага хүргүүлэв.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3¹, Сангийн сайд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2020 оны "Маягт, журам батлах тухай" 246/А/245, 2021 оны 49,А/39 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтын " 2.26.9²-т заасан даатгуулагчийн ангилал код"-ыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Илрүүлэлт:** Засгийн газрын 2021.12.14-ны өдрийн 376 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц, аймаг, сумын ИТХ-ын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох" тухай тогтоолоор 12 хүртэл орон тоотой батлагдсан байхад аймгийн ИТХ-ын ажлын алба нь 2022 онд 15 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж 3 орон тоо илүү ажилласан байна.

Энэ нь Засгийн газрын 2021.12.14-ны өдрийн 376 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц, аймаг, сумын ИТХ-ын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох" тухай тогтоолыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог батлагдсан орон тооны хязгаарт багтааж Ажиллан Засгийн газрын 2021.12.14-ны өдрийн 376 дугаар "Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц, аймаг, сумын ИТХ-ын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай" тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

¹ /Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах.;

² Даатгуулагчийн төрлийн ангилал код

2. Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн зардлыг татварын э-баримттай тулган шалгахад 43,780.0 мянган төгрөгийн худалдан авалтад төлбөрийн баримт үүсгүүлээгүй төлбөр тооцоог хийсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1³, 17.3.2⁴ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс 218820.0 мянган төгрөгийн 33 мэдээлэл хугацаа хоцроож тухай бүр мэдээлэх 3, улирал бүр мэдээлэх 3, бүтэн жилээр мэдээлэх 5 нийт 11 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг үнэн зөв мэдээлж байх.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ 17.3.1. албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ;

⁴ 17.3.2. бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Олон нийтийн цагдаад олгох урамшуулалт цалингийн НДШ төлөх ажил мэргэжлийн кодыг зөрүүлж мэдээлсэнтэй холбоотой өглөг үүссэн байна.	1	1,024.00	0	0	1	1024.0	0	0	0	0	0	0
2	Тайланд 2022 онд 15 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж 3 орон тоо илүү ажилласан байна.	1	0.00	0	0	0	0	1	0	0	0	0	0
3	Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн зардлыг татварын э-баримттай тулган шалгахад 43780000 төгрөгийн худалдан авалтад төлбөрийн баримт үүсгүүлээгүй төлбөр тооцоог хийсэн байна.	1	43,780.00	0	0	0	0	1	43,780.0	0	0	0	0
Нийт дүн		3	44,804.0	0	0	1	1024	2	43,780.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс 218820.0 мянган төгрөгийн 33 мэдээлэл хугацаа хоцроож тухай бүр мэдээлэх 3, улирал бүр мэдээлэх 3, бүтэн жилээр мэдээлэх 5 нийт 11 мэдээллийг байршуулаагүй байна	1	0	0						1	0
Дүн	1	0							1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	1	0							1	0

oOo